

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 2024 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны жилийн эцсийн байдлаар

2024 оны 11 дугаар сарын 30

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин, улирал	Хэрэгжих хугацаа, улирал	Хариуцах байгуулага	Хэрэгжилт	Байгууллагын үнэлгээ
1	Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлж, Улаанбаатар хотын зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудлуудыг бий болгох, ачаа тээврийн нэгдсэн		Ажлын явц, хувь	2022 онд 145 автобусаар парк шинэчлэлт хийсэн.	IV улирал: Нийслэлийн нийтийн тээвэрт 600-аас доошгүй автобусаар парк шинэчлэлт хийж, цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. -Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах ажлыг эхлүүлнэ.	IV улирал	ЗТХЯ, Нийслэлийн холбогдох байгууллагууд	Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтийн хүрээнд 2023 онд 35 ширхэг, 2024 онд 565 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй Yutong маркын автобус, 31 ширхэг дизель евро-5 хөдөлгүүртэй угсраа автобусаар буюу нийт 631 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 3 байгууллага 235 автобусаар 13 чиглэлд, хувийн хэвшлийн 10 аж ахуйн нэгж байгууллага 365 автобусаар 14 чиглэлд, их багтаамжийн угсраа 31 автобусаар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит 2 байгууллага 3 чиглэлд үйлчилгээ үзүүлэх төлөвлөлтийг боловсруулж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэн, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан өдөрт үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1220 болгон нэмэгдүүлсэн. Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын	100

<p>логистикийг хөгжүүлэх;</p>	<p>Улсын төсөв, нийслэлийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</p>	<p>Парк шинэчлэлт хийх автобусны тоо</p>	<p>2023 онд 381 автобусаар парк шинэчлэлт хийсэн.</p>	<p>I-II улирал: Нийслэлийн нийтийн тээвэрт 600-аас доошгүй автобусаар парк шинэчлэлт хийнэ. Аюулгүй найдвартай, олон улсын стандартын шаардлага хангасан автобусаар парк шинэчлэлт хийх чиглэлээр санаг, зөвлөмж хүргүүлсэн байна.</p>	<p>I-II улирал</p>	<p>Нийслэл</p> <p>Хугацаатай тендер зарлан Асеть ХХК шалгарсан бөгөөд "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ-г 13 ширхэг, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-г 1 ширхэг цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан.</p> <p>"Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерт шалгарсан Гео зураглал ХХК-тай 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулан ажилласан. Газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс "Эдийн засаг, хөгжлийн яам"-наас төслийн санхүүжилтийг зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Utong Bus Co., Ltd ХХК-тай хамтран 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ" байгуулсан. Тус гэрээний дагуу нийлүүлэгдэх их багтаамжийн нийтийн тээврийн автобусыг чанар стандартад хяналт тавин ажиллахаар 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Эрээн хотод очин хуваарийн дагуу 565 автобусыг Улаанбаатар хот хуртэл тээвэрлэх ажлыг зохион байгуулж, гэрээний дагуу 165.6 тэрбум төгрөгийг санхүүжилтийг зарцуулсан байна.</p> <p>"Нийтийн тээврийг хөгжүүлэх сан"-д хуримтлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс ZK6186NHG маркийн их багтаамжийн 31 угсраа автобусыг худалдан авах 22.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, эхний ээлжийн 21 автобусыг 2024 оны 09 дүгээр</p>	<p>100</p>
<p>2.1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг хийх.</p>							

			<p>I-III улирал: Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх станцын хэрэгцээ, байршил тогтооно.</p>			<p>Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх станцын хэрэгцээ, байршил тогтооно.</p>	
<p>2.2. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг байгуулах</p>	<p>Нийслэлийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</p>	<p>Ажлын явц, хувь</p>	<p>Хэрэгцээ, байршил тогтоох судалгааг хийнэ.</p>	<p>I-IV улирал: Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр</p>	<p>I-IV улирал</p>	<p>Нийслэл</p> <p>Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх станцын хэрэгцээ, байршил тогтооно.</p>	<p>100</p>

		Нийслэлийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Ажлын явц, гүйцэтгэлийн хувь	Төлөвлөлтийн шатанд	Төлөвлөлтийн Дагуу Байгуулна.	I-IV улирал	Нийслэл	<p>бөгөөд, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-г 4 ширхэг цэнэглэгч суурилуулсан ашиглаж байна.</p> <p>Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хамтарсан А/10, А/05 тушаалаар 4 ширхэг цэнэглэгчийг Дархан Уул аймгийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэн өгсөн.</p> <p>-Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж суурилуулах ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай тендер зарлан "Азсеть" ХХК шалгарсан бөгөөд "Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ-г 13 ширхэг, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-г 1 ширхэг цэнэглэх төхөөрөмж тус тус суурилуулсан.</p> <p>2023 онд Эдийн засаг хөгжлийн яамнаас Офицеруудын ордон, 120 мянгат орчимд терминалын зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулах зураг төсөл боловсруулах" тендерг Гео зураглал ХХК нь шалгарч 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн ЭЗХЯ/94 дугаартай гэрээ байгуулсан. Нийтийн тээврийн нэг маягийн 2 терминал байгуулахаар сонгосон байшилд газар чөлөөлөх асуудлаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/02/872, 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 01/02/1386, Хот байгуулалт, хөгжлийн газарт 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06/1108 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэн ажилласан боловч газар чөлөөлөх асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Эдийн засаг, хөгжлийн яамнаас төслийн санхүүжилтийг</p>
2.4	Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулна.	Нийслэлийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Ажлын явц, гүйцэтгэлийн хувь	Төлөвлөлтийн шатанд	I-II улирал: Нийтийн тээврийн нэгдсэн терминалыг 2 байршилд барих суурь судалгаа, ажлын зураг төслийг боловсруулна. III-IV улирал: Барилга байгууламжийн ажлыг эхлүүлнэ.	I-IV улирал	Нийслэл	70

							зогсоож, гэрээний хугацаа дуусгавар болсон.	
2.5.	<p>Ачаа болон такси үйлчилгээний тээврийн үйлчилгээнд одоо ашиглаж байгаа программаас мэдээлэл авч нэгдсэн тайлан гаргадаг систем хөгжүүлэх</p>	төр хувийн хэвшлийн түншлэл	Программ хөгжүүлэлт	Программ хийгдсэн. Зөвшөөрлийг цахимжуулсан.	I-IV улирал	Нийслэл	<p>"Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний систем" www.smartcar.mn цахим сайтаар "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл" авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг авч, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 6570 түр зөвшөөрлийг олгож 800,0 сая төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлсэн байна. Мөн тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим систем www.smartcar.mn сайтаар хүүхдийн автобустай холбоотой давхардсан тоогоор 66 хүсэлт ирүүлснээс 4 байгууллагын 13 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгосон. Ажилчдын автобустай холбоотой давхардсан тоогоор 262 хүсэлт ирүүлснээс шинээр 16 байгууллагын 22 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгосон.</p> <p>2024 оны 11 дүгээр сараас эхлэн Гэрэгэ киоск ХХК-тай хамтран ЕС болон Тур зөвшөөрлийг "Хур" системтэй холбосон шинэ систем нэвтрүүлэн уг зөвшөөрлийг цахимаар олгохоор программ хөгжүүлэлтийн ажлыг үе шатандаа хэрэгжүүлж байна.</p>	100
2.6.	<p>Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн автобусны зогсоолыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар тохижуулах</p>		Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй зорчих нөхцөл бүрдсэн эсэх		I-II улирал: Холбогдох стандартыг шинэчлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй зорчих нөхцөл бүрдсэн жишиг автобусны зогсоолын зураг төсөл	Нийслэл	<p>Хотын стандартын төсөлд өөрчлөлт оруулан тусгуулах саналын хүрээнд "Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлтийн танхимд тавигдах ерөнхий шаардлага"-ын "4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг бүрэн хангаж, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулан зарлан мэдээлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байна" гэснийг "4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг бүрэн хангаж, нийтийн тээврийн хэрэгсэлд бууж</p>	

<p>Чиглэлээр хамтран ажиллах</p>			<p>Боловсруулна. III-IV улирал: Жишиг автобусны зогсоолын бүтээн байгуулалтыг эхлүүлж, ашиглалтад оруулсан байна.</p>		<p>суухад саадгүй байхаар явган замын хашлагыг налуу байдлаар төлөвлөж, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулан зарлан мэдээлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байна." болгон өөрчлөх саналыг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/01/1638 албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. - Азийн хөгжлийн банк, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийт 2.5 сая ам долларын өртгөөр Чингэлтэй дүүргийн 17,18,19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт битүү 2, задгай 17 шинэ автобусны жишиг зогсоолыг ашиглалтанд оруулсан.</p>	70
<p>4.2. Авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх хог хаягдлыг боловсруулах нэгдсэн сүлжээг бий болгох</p>	<p>Хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт</p>	<p>Үйлдвэр байгуулах ТЭЗУ боловсруулсан эсэх</p>	<p>2022 онд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. III-IV улирал: Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 20 хувьд хүргэнэ.</p>	<p>I-IV улирал</p>	<p>Нийслэл</p> <p>Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын судалгааг шинэчлэх зорилгоор 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/04/835 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд авто үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсэж буй энгийн болон аюултай хог хаягдлын төрөл, тоон хэмжээ мэдээллийг нэгтгэж, үүсэж буй хог хаягдлыг устгах, дахин боловсруулах талаар ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийж мэдээллийг нэгтгэн ажилласан. Судалгаагаар Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2024 оны байдлаар бүртгэлтэй 1400 авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хог хаягдлын судалгаанд 1100 авто үйлчилгээ эрхлэгч буюу 78,6% нь хамрагдсан байна.</p>	70
<p>4.3. Аюултай ачаа тээвэрлэлтийн үйл</p>	<p>Нийслэл</p>	<p>Журамд өөрчлөлт</p>	<p>Журамд холбогдох өөрчлөлт</p>	<p>I-II улирал: Нийслэлд аюултай</p>	<p>I-IV улирал</p> <p>Нийслэл</p> <p>Аюултай ачааны тээвэрлэлт, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2024 оны 02 дугаар сарын 02-ны</p>	

ажиллагааны хяналт, бүртгэлийн тогтолцоог сайжруулах	оруулах ажлын явц	оруулах саналыг боловсруулсан.	ачааны тээвэрлэх журамд холбогдох өөрчлөлт оруулна.	ачааны тээврийн мэдээллийн санг бүрдүүлж, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулна.	<p>Хэрэгжилтийн дундаж хувь /100%*5+70%*3/</p> <p>өдрийн 01/04/360 дугаартай албан бичгийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт хүргүүлж хамтран ажиллаж байна. Үүнд:</p> <p>1.Замын цагдаагийн шалгах төхөөрөмж дээр "Ачааны автомашины төв замын зөвшөөрөл" гэсэн мэдээллийг цахимаар хянах боломжтой байхаар мэдээлэл дамжуулах сервис холболт хийгдсэн.</p> <p>2.Тээврийн цагдаагийн албанаас цахим түр зөвшөөрлийн анхааруулга хэсэгт санамж байршуулах хүсэлт ирүүлсний дагуу "Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага MNS 4978:2017" стандартын 7.8 дахь заалтын дагуу замын цагдаагийн албанд мэдэгдэж, аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж чиглэл авч, тээвэрлэлт хийхийг анхааруулж байна." гэх санамжийг байршуулсан.</p> <p>3.Тээврийн цагдаагийн албанаас "Аюултай ачаа тээвэрлэх аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгсэл, тээвэрлэлтийн хөдөлгөөний замнал, цагийн хуваарийг гаргасан зөвлөмжийг үндэслэн Нийтийн тээврийн бодлогын газраас түр зөвшөөрөл олгож эхэлсэн.</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар аюултай ачаа тээвэрлэх 22 аж ахуйн нэгж, байгууллагын 421 тээврийн хэрэгслийг бүртгэж, зөвшөөрөл өгч ажилласан байна.</p>	88,75
--	-------------------	--------------------------------	---	--	--	-------

ХЯНАСАН:
ДАРГА

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭЛТГЭСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Д.ОТГОНЖАРГАЛ

З.ЦЭВЭЭНДОРЖ

Ц.ОДМАНДАХ